

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2023. оны .11 сарын .30 өдөр

№ R-2023-74

Улаанбаатар хот

Холбогдох этгээдийн болон сонирхлын
зөрчилтэй хэлцлийг батламжлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 81 дүгээр зүйлийн 81.4.4 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, ХасБанк (“Банк”)-ны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-48 дугаар тогтоолоор батлагдсан Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг болон ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг тус тус үндэслэн:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо (“ЭУХ”) болон Аудитын хороо (“АХ”) тус тус 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хурлаараа хэлэлцээд, Банкны хувьцаа эзэмшигчтэй холбогдох этгээдтэй хийсэн энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөл бүхий 100,000,000 (нэг зуун сая) төгрөгийн үнийн дүнтэй хэлцэл (“Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл”)-ийг батламжлах зөвлөмж ТУЗ-д хүргүүлсэн болохыг;
2. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь аливаа хөнгөлөлттэй нөхцөлгүй, банкны өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд харилцагчдад санал болгож буй нөхцөлөөс илүү давуу тал олгоогүй болохыг ЭУХ болон АХ тус тус тодорхойлсон болохыг; мөн
3. ТУЗ нь ЭУХ болон АХ-ны өгсөн зөвлөмжийн дагуу Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батламжлахыг дэмжсэн болохыг тус тус дурдав.

ТОГТООХ нь:

1. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хавсралтаар батламжилсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ